



2024.10.07

# ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН БАЙДЛААР

Улаанбаатар хот

Энэхүү товхимолын дэлгэрэнгүй мэдээллийг  
[www.hdc.gov.mn](http://www.hdc.gov.mn) цахим хуудаснаас татаж харна уу!

Эрүүл мэндийн хөгжлийн төв  
Мэдээлэл, технологийн албанаас эрхлэн гаргав.

Шуудангийн хаяг: 14210 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Энхтайвны  
гудамж, 13в байр

E-mail: [admin@hdc.gov.mn](mailto:admin@hdc.gov.mn), [www.hdc.gov.mn](http://www.hdc.gov.mn)

Факс: 976-11-320633

Утас: 7011-1485  
7012-8801

<b>ГАРЧИГ</b>	
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>4</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	<b>4</b>
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>5</b>
<b>1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД</b>	<b>6</b>
1.1. Төрөлт	6
1.2. Хүүхдийн эрүүл мэнд	7
1.3. Эхийн эндэгдэл	8
1.4. Нялхсын эндэгдэл	9
1.5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	10
<b>2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>11</b>
2.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ	11
2.2 Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл	12
2.3 Жирэмсний хяналт	12
2.4 Үр хөндөлт	14
2.5 Түргэн тусламжийн дуудлага	15
2.6 Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ	17
<b>3. ХҮН АМЫН НАС БАРАЛТ</b>	<b>18</b>
<b>4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ</b>	<b>20</b>
<b>5. ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>21</b>
5.1. Халдварт өвчний нас баралт	21
5.2. Амьсгалын замын халдварт өвчин	21
5.3. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	22
5.4. Коронавируст халдвар /COVID-19/	23

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. 1 Төрсөн эх, амьд төрсөн нярайн тоо	7
Зураг 1. 2 Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд	8
Зураг 1. 3 Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд	9
Зураг 1. 4 Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар	9
Зураг 1. 5 Перинаталь эндэгдэл, 1000 нийт төрөлтөд, аймгаар	10
Зураг 1. 6 Хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд	10
Зураг 1. 7 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар	11
Зураг 2. 1 Жирэмсний эрт хяналтын хувь, аймгаар	13
Зураг 2. 2 Түргэн тусламжийн дуудлагын тоо	16
Зураг 3. 1 Нас баралт, /бодит тоогоор/	18
Зураг 5. 1 Амьсгалын замын халдварт өвчний тохиолдол	22
Зураг 5. 2 Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол	22
Зураг 5.3 Коронавируст халдварын өвчлөл, /хүйс, насны бүлгээр/	23
Зураг 5. 4 Коронавируст халдвар, аймгаар	23

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. 1 Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж, хувиар	6
Хүснэгт 1. 2 Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар	7
Хүснэгт 1. 3 Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар	8
Хүснэгт 2. 1 Эмчийн үзлэг, эмнэлгийн төрлөөр, хувиар	12
Хүснэгт 2. 2 Жирэмсний хяналт, хувиар	13
Хүснэгт 2. 3 Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт	14
Хүснэгт 2.4 Үр хөндөлтийн түвшин	15
Хүснэгт 2. 5 Түргэн тусламжийн дуудлага, аймгаар	16
Хүснэгт 2. 6 Стационарын тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд	17
Хүснэгт 3. 1 Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх хувь	19
Хүснэгт 4. 1 Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт, аймгаар	20
Хүснэгт 5. 1 Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр	21

## Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

/2023, 2024 оны эхний 9 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он	Өсөлт бууралт
1	Төрсөн эх	Бодит тоо	48732	43116	-5616
2	Амьд төрсөн хүүхэд	Бодит тоо	49033	43428	-5605
3	Амьгүй төрсөн хүүхэд	Бодит тоо	262	223	-39
		1000 нийт төрөлтөд	5.3	5.1	-0.2
4	Эхийн эндэгдэл	Бодит тоо	12	8	-4
		100 000 амьд төрөлтөд	24.5	18.4	-6.1
5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4 нас 364 хоног/	Бодит тоо	732	656	-76
		1000 амьд төрөлтөд	14.9	15.1	0.2
6	Үүнээс: Нялхсын эндэгдэл /0-364 хоног/	Бодит тоо	603	519	-84
		1000 амьд төрөлтөд	12.3	12.0	-0.3
	Үүнээс: Нярайн эндэгдэл /0-28 хоног/	Бодит тоо	386	325	-61
		1000 амьд төрөлтөд	7.9	7.5	-1.4
	Үүнээс: Нярайн эрт үеийн эндэгдэл /0-6 хоног/ Нярайн хожуу үеийн эндэгдэл /7-28 хоног/	Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	64.0	62.6	-1.4
		Бодит тоо	254	215	-39
		Нярайн эндэгдэлд эзлэх хувь	65.8	66.2	0.4
		Бодит тоо	132	110	-22
7	Перинаталь эндэгдэл	Нярайн эндэгдэлд эзлэх хувь	34.2	33.8	-0.4
		Бодит тоо	516	438	-78
8	Нийт нас баралт	1000 нийт төрөлтөд	10.5	10.0	-0.5
		Бодит тоо	12921	13219	298
9	Эмнэлгийн нас баралт	Бодит тоо	4105	4255	150
		Хувь	31.8	32.2	0.4
10	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт	Бодит тоо	989	923	-66
		Хувь	24.1	21.7	-2.4
11	Жирэмсний эрт хяналт	Хувь	92.2	92.9	0.7
12	Эмчлэгдсэн хүний тоо	Бодит тоо	764197	767199	3002
13	Ор хоног	Бодит тоо	5235515	5234761	-754
14	Халдварт өвчин	Бодит тоо	32445	27433	-5012
		10 000 хүн амд	93.8	78.3	-15.5
15	Амьсгалын замын халдварт өвчин	Бодит тоо	12258	12112	-146
		10 000 хүн амд	35.5	34.6	-0.9
16	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	Бодит тоо	7723	7887	164
		10 000 хүн амд	22.3	22.5	0.2
17	Гэдэсний халдварт өвчин	Бодит тоо	6393	6020	-373
		10 000 хүн амд	18.5	17.2	-1.3
18	Зоонозын халдварт өвчин	Бодит тоо	243	118	-125
		10 000 хүн амд	0.7	0.3	-0.4
19	Цусаар дамжих халдварт өвчин	Бодит тоо	169	123	-46
		10 000 хүн амд	0.5	0.4	-0.1
20	Бусад халдварт өвчин	Бодит тоо	5659	1173	-4486
		10 000 хүн амд	16.4	3.3	-13.1

# 1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

## 1.1. Төрөлт

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 43116 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 5616 төрөлтөөр буюу 11.5 хувиар буурсан байна. Төрөлтийн тоо аймгууд болон Улаанбаатар хотод 26-2482 төрөлтөөр буурсан үзүүлэлттэй байна.


Төрсөн эхчүүдийн 35797 нь буюу 83.0 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа бөгөөд Төв, Булган, Хэнтий, Увс, Говьсүмбэр, Ховд, Дорнод аймгуудад улсын дундажаас 0.1-1.1 хувиар өндөр байна.

2024 оны эхний 9 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 27.8 хувийг эзэлж байгаа ба 16.9 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 83.1 хувь нь хүндрэлгүй төрсөн байна.

### Хүснэгт 1.1. Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж, хувиар

№	Аймаг/хот	Төрөлтийн эзлэх хувь					20 хүртэлх насны төрөлт	35-аас дээш насны төрөлт
		Аймаг, хотын нэгдсэн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Сумын нэгдсэн эмнэлэг	Сумын эрүүл мэндийн төв	Гэртээ		
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	89.3	0.0	0.0	10.5	0.2	3.6	19.7
2	Баян-Өлгий	88.8	0.0	0.0	11.2	0.0	0.8	18.5
3	Баянхонгор	95.3	0.0	0.0	4.4	0.3	3.7	20.6
4	Булган	85.6	0.0	0.0	13.9	0.6	1.9	19.2
5	Говь-Алтай	94.6	0.0	0.0	5.1	0.3	4.3	18.6
6	Говьсүмбэр	99.6	0.0	0.0	0.0	0.4	6.6	16.5
7	Дархан-Уул	99.6	0.0	0.0	0.1	0.3	3.0	23.6
8	Дорноговь	88.5	0.0	10.8	0.6	0.1	5.1	22.4
9	Дорнод	97.7	0.0	0.0	1.9	0.4	4.7	24.6
10	Дундговь	96.3	0.0	0.0	3.7	0.0	6.1	19.0
11	Завхан	61.0	0.0	33.4	5.6	0.0	3.1	22.9
12	Орхон	99.9	0.0	0.0	0.0	0.1	3.0	25.3
13	Өвөрхангай	82.4	0.0	12.6	4.7	0.2	4.5	20.2
14	Өмнөговь	85.5	0.0	0.0	14.4	0.1	4.2	21.5
15	Сүхбаатар	95.4	0.0	0.0	4.4	0.3	4.1	25.6
16	Сэлэнгэ	54.7	0.0	41.4	3.8	0.1	4.8	23.4
17	Төв	85.3	0.0	0.0	13.3	1.4	3.4	25.5
18	Увс	90.5	0.0	0.0	9.1	0.4	2.5	19.4
19	Ховд	91.8	0.0	4.2	3.6	0.4	2.5	18.0
20	Хөвсгөл	88.5	0.0	0.0	11.2	0.3	5.2	19.1
21	Хэнтий	80.0	0.0	11.5	8.0	0.5	4.7	21.9
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>88.6</b>	<b>0.0</b>	<b>5.0</b>	<b>6.1</b>	<b>0.3</b>	<b>3.6</b>	<b>21.3</b>
23	Улаанбаатар	93.2	6.5	0.0	0.0	0.3	3.3	26.4
24	<b>Улсын дундаж</b>	<b>91.1</b>	<b>3.5</b>	<b>2.3</b>	<b>2.8</b>	<b>0.3</b>	<b>3.4</b>	<b>24.1</b>

## Зураг 1.1. Төрсөн эх, амьд төрсөн нярайн тоо



## 1.2. Хүүхдийн эрүүл мэнд

2024 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд 43428 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 5605 хүүхдээр буюу 11.4 хувиар буурчээ. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 12.8 байна.

Амьд төрсөн хүүхдийн 22384 буюу 51.5 хувь нь хүү, 21044 буюу 48.5 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 106 хүү ногдож байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 1956 нярай буюу 4.5 хувь нь 2500 грамаас доош жинтэй, 277 тохиолдол буюу 0.6 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 96.4 байна. Дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 67.2 байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5.1 байна.

### Хүснэгт 1.2. Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар

№	Аймаг/хот	Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь					Төрөлхийн гажигтай төрсөн	2500 гр-аас доош жинтэй төрсөн хүүхэд
		22-28 долоо хоногтой	29-32 долоо хоногтой	33-36 долоо хоногтой	37-41 долоо хоногтой	42 долоо хоногос дээш		
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	0.1	0.4	3.5	96.1	0.0	0.5	3.5
2	Баян-Өлгий	0.1	0.4	2.8	96.8	0.0	0.5	4.3
3	Баянхонгор	0.3	1.1	5.3	93.2	0.0	0.8	4.1
4	Булган	0.0	1.4	4.2	94.4	0.0	0.8	3.9
5	Говь-Алтай	0.0	1.4	7.4	91.2	0.0	0.8	5.2
6	Говьсүмбэр	0.0	0.0	2.5	97.5	0.0	1.6	1.6
7	Дархан-Уул	0.1	0.4	2.9	95.4	1.2	0.3	2.5
8	Дорноговь	0.3	1.0	4.0	94.6	0.1	0.8	3.7
9	Дорнод	0.2	0.6	2.4	96.8	0.0	0.3	2.6
10	Дундговь	0.2	1.2	3.7	94.6	0.2	0.9	3.3
11	Завхан	0.0	0.4	4.1	95.5	0.0	1.1	3.3
12	Орхон	0.4	0.9	5.3	93.3	0.1	0.9	5.5
13	Өвөрхангай	0.1	1.2	4.3	94.4	0.0	0.1	4.5
14	Өмнөговь	0.2	1.1	3.4	95.3	0.0	0.9	3.4
15	Сүхбаатар	0.1	0.8	5.9	93.1	0.0	1.1	3.5
16	Сэлэнгэ	0.0	0.3	3.5	95.8	0.3	0.1	2.6
17	Төв	0.4	0.9	4.8	94.0	0.0	0.2	3.7
18	Увс	0.0	0.3	4.6	95.1	0.0	0.7	3.2
19	Ховд	0.1	0.7	3.9	95.3	0.0	0.5	3.1
20	Хөвсгөл	0.1	0.5	5.3	93.7	0.5	0.9	4.0
21	Хэнтий	0.8	0.5	3.8	95.0	0.0	0.3	4.7
<b>22</b>	<b>Аймгийн дундаж</b>	<b>0.2</b>	<b>0.7</b>	<b>4.1</b>	<b>94.8</b>	<b>0.1</b>	<b>0.6</b>	<b>3.7</b>
23	Улаанбаатар	0.5	1.4	6.3	91.8	0.0	0.7	5.1
<b>24</b>	<b>Улсын дундаж</b>	<b>0.3</b>	<b>1.1</b>	<b>5.3</b>	<b>93.2</b>	<b>0.1</b>	<b>0.6</b>	<b>4.5</b>

2024 оны эхний 9 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 1411785 хүүхэд хамрагдсанаас 0.15 хувь нь туранхай, 0.12 хувь нь тураалтай, 0.14 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна.


### Хүснэгт 1.3. Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар

№	Аймаг/хот	Бүгд	Жингийн мэдээ			А амин дэм уусан	Д амин дэм уусан	Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн
			Туранхай	Тураалтай	Өсөлтийн хоцрогдолтой			
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	38313	0.30	0.44	0.32	20.47	43.06	13.47
2	Баян-Өлгий	31066	0.39	0.32	0.09	30.66	23.73	7.52
3	Баянхонгор	56479	0.28	0.45	0.34	17.20	29.93	4.39
4	Булган	17588	0.14	0.10	0.15	25.36	12.22	1.86
5	Говь-Алтай	18509	0.28	0.42	0.90	23.10	39.25	4.68
6	Говьсүмбэр	7416	0.03	0.01	0.03	17.84	18.93	4.38
7	Дархан-Уул	67865	0.18	0.02	0.09	13.05	84.13	1.19
8	Дорноговь	32658	0.10	0.21	0.22	15.86	60.23	1.21
9	Дорнод	44127	0.15	0.14	0.16	17.52	43.87	0.65
10	Дундговь	16811	0.03	0.02	0.02	16.66	44.28	0.62
11	Завхан	29760	0.04	0.02	0.06	20.14	51.23	7.35
12	Орхон	68848	0.18	0.04	0.18	11.16	80.72	0.12
13	Өвөрхангай	34334	0.17	0.14	0.17	24.28	51.41	1.73
14	Өмнөговь	30610	0.37	0.15	0.26	20.13	65.20	0.91
15	Сүхбаатар	15406	0.40	0.08	0.33	25.39	33.50	9.36
16	Сэлэнгэ	35142	0.09	0.03	0.02	21.73	15.21	2.58
17	Төв	15704	0.11	0.10	0.08	29.93	31.39	3.90
18	Увс	45675	0.18	0.28	0.37	20.41	38.23	0.30
19	Ховд	51951	0.10	0.08	0.03	14.54	47.46	0.62
20	Хөвсгөл	42091	0.02	0.05	0.09	24.41	58.22	7.46
21	Хэнтий	16461	0.22	0.05	0.10	22.81	55.21	8.86
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>716814</b>	<b>0.18</b>	<b>0.16</b>	<b>0.18</b>	<b>19.12</b>	<b>49.49</b>	<b>3.38</b>
23	Улаанбаатар	694971	0.11	0.09	0.10	13.41	27.12	1.30
24	<b>Улсын дундаж</b>	<b>1411785</b>	<b>0.15</b>	<b>0.12</b>	<b>0.14</b>	<b>16.31</b>	<b>38.48</b>	<b>2.36</b>

### 1.3. Эхийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар эхийн эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдэж, 100000 амьд төрөлтөд 18.4 ногдож байна. Сүүлийн 10 жилийн дундажаар 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 34.3 байна.

Зураг 1.2. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд





### 1.4. Нялхсын эндэгдэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 519 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.0 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 84 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийн 62.6 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 7.5 байна. Нярайн эндэгдлийн нийт 325 тохиолдлын 215 буюу 66.2 хувь нь эрт үеийн эндэгдэл, 110 буюу 33.8 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна.

Зураг 1.3. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд




2024 оны эхний 9 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг аймгуудаар харьцуулбал: Төв (21.2), Завхан (17.8), Хэнтий (17.6), Архангай (17.3), Хөвсгөл (15.9), Говь-Алтай (15.7), Баян-Өлгий (14.8), Увс (14.1), Өмнөговь (13.4), Баянхонгор (13.1), Өвөрхангай (12.3) аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс 0.3-9.3 өндөр байна.

Зураг 1.4. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар



Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 57.6 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 15.8 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 7.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1.5. Перинаталь эндэгдэл, 1000 нийт төрөлтөд, аймгаар



### 1.5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 656 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 15.1 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76 тохиолдлоор буурсан байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 381 тохиолдол буюу 58.1 хувь нь эрэгтэй, 275 тохиолдол буюу 41.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Нийт тохиолдлын 24.3 хувь нь эмнэлгээс гадуур, 75.7 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 24.5 хувийг эзэлж байна.


Зураг 1.6. Хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд



Шалтгаанаар авч үзвэл: Нийт эндэгдлийн 84.2 хувь нь өвчнөөр, 15.8 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 45.6 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 14.3 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 8.5 хувийг тус тус эзэлж байна.

Аймгуудаар харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Төв (28.3), Завхан (24.6), Хэнтий (22.6), Архангай (22.2), Говь-Алтай (20.4), Хөвсгөл (20.0), Булган (19.4), Баян-Өлгий (19.0), Увс (18.2), Дорноговь (16.7), Өвөрхангай (15.3) аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс 0.2-13.2 өндөр байна.

Зураг 1.7. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар



## 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1. Амбулаторийн тусламж үйлчилгээ

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 17595261 эмчийн үзлэг хийгдсэнээс 24.6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 57.8 хувийг өвчний учир амбулаторт, 7.1 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 10.5 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 1175 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчний учир амбулаторийн үзлэг 3.5 хувиар буурч, идэвхитэй хяналт 1.2, гэрийн үзлэг 1.5, урьдчилан сэргийлэх үзлэг 0.8 хувиар тус тус өссөн байна.

## Хүснэгт 2.1. Эмчийн үзлэг, эмнэлгийн төрлөөр, хувиар

№	Аймаг/хот	Багийн бага эмч	Сумын бага эмч	Сумын эх баригч бага эмч	Сумын их эмч	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Өрхийн эмчийн үзлэг	Бусад
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	14.7	2.8	3.2	22.3	37.7	15.2	4.1
2	Баян-Өлгий	7.6	0.5	3.2	16.2	41.8	25.6	5.1
3	Баянхонгор	10.9	2.5	3.2	12.9	48.6	19.6	2.2
4	Булган	10.6	3.2	4.4	17.0	50.4	10.9	3.5
5	Говь-Алтай	8.4	0.3	2.8	10.2	52.0	19.0	7.3
6	Говьсүмбэр	0.0	0.0	0.4	6.4	55.1	27.6	10.4
7	Дархан-Уул	1.5	0.4	0.8	3.6	34.9	39.6	19.1
8	Дорноговь	5.0	1.8	1.3	25.0	38.7	20.5	7.8
9	Дорнод	2.9	0.7	2.1	10.4	46.3	32.4	5.1
10	Дундговь	7.4	0.2	3.1	18.0	58.0	10.8	2.5
11	Завхан	7.6	1.8	2.5	28.5	34.3	20.6	4.8
12	Орхон	0.0	0.0	0.0	1.2	24.8	46.2	27.8
13	Өвөрхангай	6.6	0.5	2.3	10.5	51.9	22.1	6.1
14	Өмнөговь	4.3	0.9	2.4	13.9	40.0	23.4	15.3
15	Сүхбаатар	7.4	2.3	3.3	16.2	55.0	14.2	1.7
16	Сэлэнгэ	0.4	5.9	4.5	13.1	45.2	23.3	7.7
17	Төв	18.8	3.2	6.2	15.3	42.4	11.7	2.3
18	Увс	8.5	1.3	3.7	17.0	47.7	16.5	5.2
19	Ховд	9.0	0.8	2.0	10.5	45.8	26.0	5.9
20	Хөвсгөл	13.8	2.8	5.4	16.1	29.0	27.6	5.3
21	Хэнтий	3.2	1.9	2.3	28.2	33.6	25.9	4.8
<b>22</b>	<b>Аймгийн дундаж</b>	<b>6.7</b>	<b>1.6</b>	<b>2.7</b>	<b>14.0</b>	<b>41.0</b>	<b>25.3</b>	<b>8.7</b>
23	Улаанбаатар	0.0	0.0	0.0	0.6	22.1	31.5	45.7
<b>24</b>	<b>Улсын дундаж</b>	<b>2.6</b>	<b>0.6</b>	<b>1.0</b>	<b>5.7</b>	<b>29.3</b>	<b>29.1</b>	<b>31.6</b>

## 2.2. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 1073711 (50.3%) хүн хамрагдсан бөгөөд 39.3 хувь нь эрэгтэй, 60.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.6 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна.

Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 881486 (65.6%) хүн хамрагдсанаас 38.9 хувь нь эрэгтэй, 61.1 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна.

Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 236923 (26.0%) хүн хамрагдсанаас 59 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна.

### 2.2.1. Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 62141 (28.3%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 4.1 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй,

үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 26 тохиолдол бүртгэгдсэн байна. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 380493 эмэгтэй хамрагдсанаас 1134 (0.3%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

### 2.3. Жирэмсний хяналт


Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 43514 эмэгтэйчүүд хамрагдсан ба 92.9 хувь нь эхний 3 сартайд, 6.4 хувь нь 4-6 сартайд, 0.7 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 96.8 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 4.1 хувь нь цус багадалттай байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 92.5 хувь, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.4 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 98.9 хувь, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 98.1 хувь нь хамрагдсан байна.

#### Хүснэгт 2.2. Жирэмсний хяналт, хувиар

№	Аймаг/хот	Хяналтад авсан хувь			6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж төрсөн	Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүд
		Эхний 3 сартайд	4-6 сартайд	7 ба түүнээс дээш сартайд		
А	Б	1	2	3	4	5
1	Архангай	92.4	6.7	1.0	75.4	4.1
2	Баян-Өлгий	95.2	4.5	0.3	61.6	8.3
3	Баянхонгор	91.3	8.1	0.5	91.3	4.9
4	Булган	94.0	6.0	0.0	75.0	2.5
5	Говь-Алтай	94.3	4.9	0.8	87.0	0.2
6	Говьсүмбэр	93.4	6.6	0.0	81.9	0.0
7	Дархан-Уул	96.8	3.1	0.1	79.4	11.5
8	Дорноговь	87.0	11.0	2.0	84.5	4.9
9	Дорнод	95.8	4.1	0.1	82.4	3.4
10	Дундговь	97.0	2.5	0.5	93.2	0.0
11	Завхан	92.6	7.2	0.2	91.5	2.7
12	Орхон	99.5	0.5	0.0	76.2	2.3
13	Өвөрхангай	93.8	5.6	0.7	76.3	1.5
14	Өмнөговь	90.5	8.3	1.2	93.4	1.0
15	Сүхбаатар	87.4	12.0	0.6	94.1	2.5
16	Сэлэнгэ	89.2	8.9	2.0	89.8	1.1
17	Төв	93.1	6.2	0.7	90.8	1.2
18	Увс	96.4	3.4	0.3	88.5	1.0
19	Ховд	94.3	5.1	0.6	87.4	3.1
20	Хөвсгөл	91.4	7.9	0.8	73.6	1.5
21	Хэнтий	92.6	6.7	0.7	83.2	1.2
<b>22</b>	<b>Аймгийн дундаж</b>	<b>93.4</b>	<b>6.0</b>	<b>0.6</b>	<b>81.8</b>	<b>3.4</b>
23	Улаанбаатар	92.4	6.8	0.8	84.1	4.7
<b>24</b>	<b>Улсын дундаж</b>	<b>92.9</b>	<b>6.4</b>	<b>0.7</b>	<b>83.0</b>	<b>4.1</b>

Зураг 2.1. Жирэмсний эрт хяналтын хувь, аймгаар



Хүснэгт 2.3. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт

№	Аймаг/хот	Трихомониаз	Үүнээс: Эерэг	Заг хүйтэн	Үүнээс: Эерэг	Тэмбүү	Үүнээс: Эерэг
1	Архангай	692	0	692	0	927	22
2	Баян-Өлгий	1147	0	1147	0	1760	0
3	Баянхонгор	1066	53	1066	4	1099	18
4	Булган	461	3	462	3	496	4
5	Говь-Алтай	456	0	481	0	579	7
6	Говьсүмбэр	193	3	193	0	193	3
7	Дархан-Уул	1404	17	1404	0	1404	17
8	Дорноговь	850	4	850	1	958	8
9	Дорнод	772	12	772	2	933	24
10	Дундговь	374	0	331	0	396	1
11	Завхан	511	1	511	0	599	2
12	Орхон	1286	22	1286	2	1286	7
13	Өвөрхангай	1111	0	1111	0	1348	9
14	Өмнөговь	996	14	996	2	1084	8
15	Сүхбаатар	691	13	691	0	691	6
16	Сэлэнгэ	860	15	820	2	1180	5
17	Төв	680	15	677	0	823	8
18	Увс	793	1	839	3	1043	2
19	Ховд	1098	0	1074	0	1168	3
20	Хөвсгөл	1195	11	1195	11	1240	28
21	Хэнтий	686	4	683	0	850	2
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>17322</b>	<b>188</b>	<b>17281</b>	<b>30</b>	<b>20057</b>	<b>184</b>
23	Улаанбаатар	22907	264	22907	18	22960	345
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>40229</b>	<b>452</b>	<b>40188</b>	<b>48</b>	<b>43017</b>	<b>529</b>

## 2.4. Үр хөндөлт

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 8895 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн байна. Өмнөх оны мөн үеэс 453 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Нийт үр хөндөлтийн 449 тохиолдол буюу 5.0 хувийг хожуу үр хөндөлт, 402 тохиолдол буюу 4.5 хувийг өсвөр насны үр хөндөлт эзэлж байна.


#### Хүснэгт 2.4. Үр хөндөлтийн түвшин

№	Аймаг/хот	Үр хөндөлтийн тоо			Үр хөндөлтийн харьцаа (1000 амьд төрөлтөд)		
		2023 он	2024 он	5 жилийн дундаж	2023 он	2024 он	5 жилийн дундаж
1	Архангай	103	136	168	98.4	167.7	156.2
2	Баян-Өлгий	113	47	73	54.0	24.8	35.1
3	Баянхонгор	52	74	120	42.1	69.4	92.0
4	Булган	41	27	49	86.3	75.0	94.2
5	Говь-Алтай	32	59	48	43.2	92.8	56.8
6	Говьсүмбэр	19	10	25	70.4	41.0	85.5
7	Дархан-Уул	375	295	409	245.3	212.7	263.2
8	Дорноговь	258	246	256	315.0	316.2	274.4
9	Дорнод	116	151	239	100.7	147.6	193.0
10	Дундговь	90	75	79	172.7	175.6	141.7
11	Завхан	9	5	17	10.3	6.8	18.9
12	Орхон	168	155	155	98.5	104.4	88.4
13	Өвөрхангай	120	88	118	80.2	67.5	75.7
14	Өмнөговь	321	344	394	300.8	384.4	367.9
15	Сүхбаатар	77	80	74	82.3	108.0	82.0
16	Сэлэнгэ	27	20	18	27.0	23.2	16.7
17	Төв	46	72	62	73.0	127.2	88.7
18	Увс	179	207	191	131.6	171.6	142.2
19	Ховд	31	35	25	21.7	28.6	17.0
20	Хөвсгөл	22	13	29	13.1	9.0	16.5
21	Хэнтий	46	52	62	46.6	65.4	60.3
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>2245</b>	<b>2191</b>	<b>2611</b>	<b>97.4</b>	<b>110.2</b>	<b>109.0</b>
23	Улаанбаатар	7103	6704	6931	273.3	284.8	260.2
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>9348</b>	<b>8895</b>	<b>9542</b>	<b>190.6</b>	<b>204.8</b>	<b>188.6</b>

#### 2.5. Түргэн тусламжийн дуудлага

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 597676 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 6.8 хувийг алсын, 10.2 хувийг осол, гэмтлийн дуудлага эзэлж байна.

## Зураг 2.2. Түргэн тусламжийн дуудлагын тоо



## Хүснэгт 2.5. Түргэн тусламжийн дуудлагын тоо

№	Аймаг/хот	Түргэн тусламжийн дуудлага			Бүх дуудлагад эзлэх хувь	Алсын дуудлагын эзлэх хувь	Осол, гэмтлийн дуудлагын эзлэх хувь
		Бүгд	Алсын дуудлага	Осол, гэмтлийн дуудлага			
1	Архангай	11621	2567	550	1.9	22.1	4.7
2	Баян-Өлгий	11989	2820	398	2.0	23.5	3.3
3	Баянхонгор	10597	2513	456	1.8	23.7	4.3
4	Булган	9868	1244	305	1.7	12.6	3.1
5	Говь-Алтай	9732	1714	249	1.6	17.6	2.6
6	Говьсүмбэр	3600	140	109	0.6	3.9	3.0
7	Дархан-Уул	11920	289	1188	2.0	2.4	10.0
8	Дорноговь	12025	1448	587	2.0	12.0	4.9
9	Дорнод	7180	661	319	1.2	9.2	4.4
10	Дундговь	7445	1535	218	1.2	20.6	2.9
11	Завхан	15371	2214	295	2.6	14.4	1.9
12	Орхон	11656	231	1917	2.0	2.0	16.4
13	Өвөрхангай	13065	3414	615	2.2	26.1	4.7
14	Өмнөговь	7109	1167	602	1.2	16.4	8.5
15	Сүхбаатар	12162	2438	290	2.0	20.0	2.4
16	Сэлэнгэ	19970	3027	878	3.3	15.2	4.4
17	Төв	11896	3537	523	2.0	29.7	4.4
18	Увс	10631	3102	230	1.8	29.2	2.2
19	Ховд	9700	2084	390	1.6	21.5	4.0
20	Хөвсгөл	15041	2203	371	2.5	14.6	2.5
21	Хэнтий	15582	1977	342	2.6	12.7	2.2
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>238160</b>	<b>40325</b>	<b>10832</b>	<b>39.8</b>	<b>16.9</b>	<b>4.5</b>
23	Улаанбаатар	359516	125	50398	60.2	0.0	14.0
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>597676</b>	<b>40450</b>	<b>61230</b>	<b>100.0</b>	<b>6.8</b>	<b>10.2</b>



## 2.6 Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 767199 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 5234761 ор хоног ашигласан байна. Улсын дунджаар ор ашиглалтын хувь 64.9, дундаж ор хоног 6.8 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 3002 хүнээр өсөж, ор хоног 754 тохиолдлоор тус тус буурсан байна.

### Хүснэгт 2.6. Стационарын тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд


№	Аймаг/хот	Орны тоо	Орны фонд ашиглалт	Орны фонд ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт
1	Архангай	594	173.5	63.3	7.0	25.2
2	Баян-Өлгий	1016	178.5	65.1	7.0	26.0
3	Баянхонгор	691	183.9	67.1	7.0	26.8
4	Булган	309	210.2	76.7	7.1	30.0
5	Говь-Алтай	493	163.3	59.6	7.0	23.5
6	Говьсүмбэр	176	184.1	67.2	7.0	27.1
7	Дархан-Уул	843	188.4	68.7	7.0	27.3
8	Дорноговь	549	182.0	66.4	7.0	26.2
9	Дорнод	584	177.2	64.7	6.7	26.7
10	Дундговь	368	162.1	59.2	7.3	22.5
11	Завхан	633	163.4	59.6	6.7	24.4
12	Орхон	941	197.6	72.1	6.8	29.4
13	Өвөрхангай	1044	151.0	55.1	6.9	22.3
14	Өмнөговь	767	109.7	40.0	6.3	17.7
15	Сүхбаатар	530	197.8	72.2	7.8	25.7
16	Сэлэнгэ	878	155.5	56.8	7.0	22.4
17	Төв	565	172.9	63.1	7.2	24.3
18	Увс	562	205.0	74.8	6.7	31.0
19	Ховд	820	200.6	73.2	7.6	26.6
20	Хөвсгөл	1011	147.6	53.9	6.7	22.5
21	Хэнтий	602	213.5	77.9	8.0	27.1
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>13976</b>	<b>174.5</b>	<b>63.7</b>	<b>7.0</b>	<b>25.2</b>
23	Улаанбаатар	15467	180.8	66.0	6.7	27.5
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>29443</b>	<b>177.8</b>	<b>64.9</b>	<b>6.8</b>	<b>26.4</b>

### 3. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

2024 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 13219 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 298 тохиолдлоор өссөн байна.

Нийт нас баралтын 8377 тохиолдол буюу 63.4 хувь нь эрэгтэй, 4842 буюу 36.6 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 32.2 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 923 тохиолдол буюу 21.7 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 66 тохиолдлоор буурсан байна.

Зураг 3.1. Нас баралт, /бодит тоогоор/



Нас баралтын түвшин 1000 хүн амд 3.9 байна. Нас баралтын 3.9 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5.0 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 2355 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 17.8 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 123 тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 7.0 байна.

*Хүснэгт 3.1. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх хувь*

№	Аймаг/хот	Амиа хорлолт	Бусдад хорлогдсон	Үйлдвэрийн осол	Зам тээврийн осол	Бусад осол	Тодорхойгүй
A	Б	1	2	3	4	5	6
1	Архангай	14.7	1.3	1.3	30.7	52.0	0.0
2	Баян-Өлгий	11.6	0.0	0.0	46.5	41.9	0.0
3	Баянхонгор	29.8	4.3	0.0	36.2	29.8	0.0
4	Булган	25.0	2.8	0.0	22.2	50.0	0.0
5	Говь-Алтай	20.0	2.9	0.0	37.1	40.0	0.0
6	Говьсүмбэр	4.8	0.0	4.8	28.6	61.9	0.0
7	Дархан-Уул	10.3	3.4	3.4	10.3	72.4	0.0
8	Дорноговь	17.9	1.8	0.0	37.5	42.9	0.0
9	Дорнод	20.5	6.8	0.0	13.6	59.1	0.0
10	Дундговь	15.0	5.0	0.0	25.0	55.0	0.0
11	Завхан	28.1	9.4	0.0	37.5	25.0	0.0
12	Орхон	3.8	3.8	0.0	7.7	84.6	0.0
13	Өвөрхангай	20.0	4.0	0.0	28.0	48.0	0.0
14	Өмнөговь	24.1	3.4	0.0	24.1	44.8	3.4
15	Сүхбаатар	18.4	7.9	10.5	34.2	28.9	0.0
16	Сэлэнгэ	20.3	2.5	0.0	29.1	48.1	0.0
17	Төв	17.1	1.2	2.4	37.8	41.5	0.0
18	Увс	28.8	5.1	0.0	27.1	39.0	0.0
19	Ховд	15.4	0.0	0.0	23.1	57.7	3.8
20	Хөвсгөл	37.1	7.2	0.0	15.5	40.2	0.0
21	Хэнтий	28.4	9.0	3.0	17.9	41.8	0.0
<b>22</b>	<b>Аймгийн дундаж</b>	<b>21.4</b>	<b>4.0</b>	<b>1.1</b>	<b>27.5</b>	<b>45.7</b>	<b>0.2</b>
23	Улаанбаатар	12.0	8.3	0.4	6.6	64.5	8.1
<b>24</b>	<b>Улсын дундаж</b>	<b>16.0</b>	<b>6.5</b>	<b>0.7</b>	<b>15.4</b>	<b>56.6</b>	<b>4.8</b>

#### 4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ

2024 оны эхний 9 сарын байдлаар аймаг хотын нэгдсэн эмнэлгүүдэд нас баралтын 3373 тохиолдол бүртгэгдсэнээс 40.9 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна.

Задлан шинжилгээний хувь Дундговь, Өвөрхангай, Архангай, Баян-Өлгий, Төв, Булган, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудад аймгийн дундаж үзүүлэлтээс 2.3-25.6 хувиар доогуур үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд үндсэн оношийн зөрүү 28 тохиолдол бүртгэгдэж, оношийн зөрүүний хувь 2.5 байна.

##### Хүснэгт 4.1. Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт, аймгаар

№	Аймаг/хот	Эдийн шинжилгээ	Эсийн шинжилгээ	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нас баралт	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт хийгдсэн задлан шинжилгээ		Аймаг, хотын нэгдсэн эмнэлгийн амьгүй төрөлт	Амьгүй төрөлтөд хийгдсэн задлан шинжилгээ	Задлан шинжилгээ хийгээгүй	Задлан шинжилгээний хувь	Оношийн зөрүү /тоо/	Оношийн зөрүүний хувь
					Эмгэг судлалын	Шүүх эмнэлгийн						
1	Архангай	712	943	54	15	5	2	1	34	37.5%	0	0.0%
2	Баян-Өлгий	596	2061	34	9	0	5	4	25	33.3%	1	7.7%
3	Баянхонгор	1117	3014	51	23	6	4	1	22	54.5%	3	12.5%
4	Булган	331	2004	24	4	3	0	0	17	29.2%	0	0.0%
5	Говь-Алтай	703	1436	32	15	2	2	2	15	55.9%	0	0.0%
6	Говьсүмбэр	176	347	29	2	3	0	0	24	17.2%	0	0.0%
7	Дархан-Уул	1247	4236	151	25	8	5	5	118	24.4%	1	3.3%
8	Дорноговь	716	1380	54	23	5	0	0	26	51.9%	3	13.0%
9	Дорнод	875	4043	71	24	9	0	0	38	46.5%	0	0.0%
10	Дундговь	365	1256	31	9	4	1	0	18	40.6%	0	0.0%
11	Завхан	273	827	22	8	2	0	1	12	50.0%	0	0.0%
12	Орхон	1955	2194	90	48	6	3	0	36	58.1%	3	6.3%
13	Өвөрхангай	1153	3781	47	16	2	1	1	29	39.6%	0	0.0%
14	Өмнөговь	347	194	33	11	7	0	0	15	54.5%	0	0.0%
15	Сүхбаатар	690	2163	34	17	6	0	0	11	67.6%	1	5.9%
16	Сэлэнгэ	322	968	31	12	1	1	1	18	43.8%	0	0.0%
17	Төв	1241	1838	56	16	1	0	0	39	30.4%	0	0.0%
18	Увс	1330	2487	43	17	1	3	2	25	43.5%	1	5.3%
19	Ховд	805	685	44	20	2	4	2	22	50.0%	0	0.0%
20	Хөвсгөл	870	4352	71	27	6	5	0	38	43.4%	2	7.4%
21	Хэнтий	459	1849	51	22	5	0	0	24	52.9%	0	0.0%
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>16283</b>	<b>42058</b>	<b>1053</b>	<b>363</b>	<b>84</b>	<b>36</b>	<b>20</b>	<b>606</b>	<b>42.9%</b>	<b>15</b>	<b>3.9%</b>
23	Улаанбаатар	46874	22934	2320	699	229	109	43	1392	40.0%	13	1.8%
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>63157</b>	<b>64992</b>	<b>3373</b>	<b>1062</b>	<b>313</b>	<b>145</b>	<b>63</b>	<b>1998</b>	<b>40.9%</b>	<b>28</b>	<b>2.5%</b>

## 5. ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 26 төрлийн 27433 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 78.3 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 5012 тохиолдлоор буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 15.5-оор буурсан байна.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнийг аймгуудаар харьцуулбал: Дорнод (178.1), Өмнөговь (167.4), Дорноговь (112.6), Баянхонгор (110.9), Төв (98.4), Дархан-Уул (94.0), Говь-Алтай (87.4), Говьсүмбэр (78.7) аймгуудад болон Улаанбаатар (84.3) хотод улсын дундаж үзүүлэлтээс 0.4-99.8 өндөр байна.

### Хүснэгт 5.1. Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр

№	Халдварт өвчний төрөл	Өвчлөл			Нас баралт		
		2023 он	2024 он	Өсөлт/ Бууралт	2023 он	2024 он	Өсөлт/ Бууралт
1	Амьсгалын замын халдварт өвчин	12258	12112	-146	36	34	-2
2	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	7723	7887	164	3	2	-1
3	Гэдэсний халдварт өвчин	6393	6020	-373	1	0	-1
4	Зоонозын халдварт өвчин	243	118	-125	4	2	-2
5	Цусаар дамжих халдварт өвчин	169	123	-46	7	8	1
6	Бусад халдварт өвчин	5659	1173	-4486	8	2	-6
7	<b>Нийт халдварт өвчин</b>	<b>32445</b>	<b>27433</b>	<b>-5012</b>	<b>59</b>	<b>48</b>	<b>-11</b>


### 5.1. Халдварт өвчний нас баралт

Улсын хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар халдварт өвчний нас баралтын нийт 48 тохиолдол бүртгэгдсэнээс сүрьеэ (34), нярайн бактерт үжил (6), хачигт энцефалит (2), коронавируст халдвар (2), вирүст хепатит (2), төрөлхийн тэмбүү (2) тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

### 5.2. Амьсгалын замын халдварт өвчин

2024 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 12112 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 44.2 хувийг эзэлж байна. Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 146 тохиолдлоор буурсан байна.

**Зураг 5.1 Амьсгалын замын халдварт өвчний тохиолдол**




### 5.3. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин

2024 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 7887 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 28.8 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 164 тохиолдлоор өссөн байна.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 46.6 хувийг тэмбүү, 32.8 хувийг заг хүйтэн, 20.4 хувийг трихомониаз, 0.2 хувийг ХДХВ/ДОХ тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 579 тохиолдлоор өссөн ба 10000 хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөл Өмнөговь (14.2), Дорнод (12.8), Говьсүмбэр (12.2), Баянхонгор (11.9) аймгууд болон Улаанбаатар хотод (14.7) улсын дундаж үзүүлэлтээс 1.4-4.2 өндөр байна.


**Зураг 5.2. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол**



## 5.4. Коронавируст халдвар /COVID-19/

2024 оны эхний 9 сарын байдлаар коронавируст халдварын 183 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.5 ногдож байна. Коронавируст халдварын шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 5.3. Коронавируст халдварын өвчлөл, /хүйс, насны бүлгээр/



Зураг 5.4. Коронавируст халдварын өвчлөл, 10 000 хүн амд



## Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2023, 2024 оны эхний 9 сарын байдлаар

Аймаг хот	Төрсөн эх				Амьд төрсөн хүүхэд				Амьгүй төрсөн хүүхэд		
	2023	2024	5 жилийн дундаж	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
1. Архангай	1045	812	1071	1047	811	1074		6	5		
2. Баян-Өлгий	2074	1887	2074	2092	1898	2085		15	10		
3. Баянхонгор	1225	1063	1298	1236	1066	1306		3	6		
4. Булган	473	360	517	475	360	518		2	2		
5. Говь-Алтай	738	630	837	740	636	842		7	2		
6. Говьсүмбэр	269	243	293	270	244	295		0	0		
7. Дархан-Уул	1527	1380	1545	1529	1387	1555		9	7		
8. Дорноговь	817	772	926	819	778	933		3	1		
9. Дорнод	1144	1015	1232	1152	1023	1240		8	2		
10. Дундговь	518	427	554	521	427	556		0	2		
11. Завхан	871	733	896	874	731	901		3	6		
12. Орхон	1702	1473	1739	1705	1485	1748		6	5		
13. Өвөрхангай	1488	1298	1552	1496	1304	1555		5	3		
14. Өмнөговь	1068	891	1067	1067	895	1070		8	2		
15. Сүхбаатар	932	735	903	936	741	908		4	0		
16. Сэлэнгэ	993	860	1069	999	861	1075		5	4		
17. Төв	623	564	693	630	566	696		2	1		
18. Увс	1349	1196	1339	1360	1206	1344		6	4		
19. Ховд	1417	1218	1441	1430	1225	1450		2	7		
20. Хөвсгөл	1675	1448	1773	1682	1450	1778		7	9		
21. Хэнтий	981	790	1016	987	795	1021		4	5		
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>22929</b>	<b>19795</b>	<b>23835</b>	<b>23047</b>	<b>19889</b>	<b>23951</b>		<b>105</b>	<b>83</b>		
22. Улаанбаатар	25803	23321	26398	25986	23539	26636		157	140		
<b>Улсын дүн</b>	<b>48732</b>	<b>43116</b>	<b>50233</b>	<b>49033</b>	<b>43428</b>	<b>50586</b>		<b>262</b>	<b>223</b>		



## Эхийн эндэгдэл, 2023, 2024 оны эхний 9 сарын байдлаар

Аймаг хот	Эхийн эндэгдэл /бодит тоо/		Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/		
	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	5 жилийн дундаж
1. Архангай	0	0	0.0	0.0	55.9
2. Баян-Өлгий	0	0	0.0	0.0	76.7
3. Баянхонгор	0	0	0.0	0.0	30.6
4. Булган	0	0	0.0	0.0	0.0
5. Говь-Алтай	0	0	0.0	0.0	0.0
6. Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0.0
7. Дархан-Уул	0	0	0.0	0.0	0.0
8. Дорноговь	1	0	122.1	0.0	64.3
9. Дорнод	0	0	0.0	0.0	32.2
10. Дундговь	0	0	0.0	0.0	0.0
11. Завхан	0	0	0.0	0.0	22.2
12. Орхон	0	0	0.0	0.0	11.4
13. Өвөрхангай	0	1	0.0	76.7	38.6
14. Өмнөговь	0	0	0.0	0.0	0.0
15. Сүхбаатар	0	1	0.0	135.0	44.1
16. Сэлэнгэ	0	1	0.0	116.1	55.8
17. Төв	0	0	0.0	0.0	57.4
18. Увс	0	0	0.0	0.0	0.0
19. Ховд	0	0	0.0	0.0	69.0
20. Хөвсгөл	0	0	0.0	0.0	45.0
21. Хэнтий	0	0	0.0	0.0	19.6
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4.3</b>	<b>15.1</b>	<b>33.4</b>
22. Улаанбаатар	11	5	42.3	21.2	49.6
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>12</b>	<b>8</b>	<b>24.5</b>	<b>18.4</b>	<b>41.9</b>

## Төрсөн хүүхдийн мэдээ, 2024 оны эхний 9 сарын байдлаар байдлаар

Аймаг хот	Амьд төрсөн хүүхэд					Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь	2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхдийн эзлэх хувь	2023 онд	2024 онд
1. Архангай	811	432	379	96.5	3.5	5.7	6.1
2. Баян-Өлгий	1898	980	918	99.8	4.3	7.1	5.2
3. Баянхонгор	1066	549	517	98.5	4.1	2.4	5.6
4. Булган	360	187	173	93.6	3.9	4.2	5.5
5. Говь-Алтай	636	332	304	98.3	5.2	9.4	3.1
6. Говьсүмбэр	244	135	109	97.5	1.6	0.0	0.0
7. Дархан-Уул	1387	696	691	98.8	2.5	5.9	5.0
8. Дорноговь	778	437	341	96.5	3.7	3.6	1.3
9. Дорнод	1023	541	482	99.5	2.6	6.9	2.0
10. Дундговь	427	213	214	99.3	3.3	0.0	4.7
11. Завхан	731	368	363	99.0	3.3	3.4	8.1
12. Орхон	1485	732	753	99.3	5.5	3.5	3.4
13. Өвөрхангай	1304	667	637	97.7	4.5	3.3	2.3
14. Өмнөговь	895	468	427	99.2	3.4	7.4	2.2
15. Сүхбаатар	741	370	371	90.8	3.5	4.3	0.0
16. Сэлэнгэ	861	442	419	93.3	2.6	5.0	4.6
17. Төв	566	301	265	97.7	3.7	3.2	1.8
18. Увс	1206	621	585	97.0	3.2	4.4	3.3
19. Ховд	1225	635	590	99.3	3.1	1.4	5.7
20. Хөвсгөл	1450	738	712	97.7	4.0	4.1	6.2
21. Хэнтий	795	416	379	98.4	4.7	4.0	6.3
<b>Аймгийн дүн</b>	<b>19889</b>	<b>10260</b>	<b>9629</b>	<b>97.9</b>	<b>3.7</b>	<b>4.5</b>	<b>4.2</b>
22. Улаанбаатар	23539	12124	11415	95.1	5.1	6.0	5.9
<b>Улсын дүн</b>	<b>43428</b>	<b>22384</b>	<b>21044</b>	<b>96.4</b>	<b>4.5</b>	<b>5.3</b>	<b>5.1</b>

## Хүүхдийн эндэгдэл, 2023, 2024 оны эхний 9 сарын байдлаар

Аймаг хот	Нялхсын эндэгдэл				Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/					
	2023 онд		5 жилийн дундаж		2023 онд		5 жилийн дундаж		2023 онд		5 жилийн дундаж		2024 онд	
	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд
1. Архангай	9	14	13	8.6	17.3	12.1	15	18	14.3	22.2	17.1	14.3	22.2	17.1
2. Баян-Өлгий	41	28	33	19.6	14.8	15.6	51	36	42	19.0	19.9	24.4	19.0	19.9
3. Баянхонгор	10	14	13	8.1	13.1	9.8	14	16	17	11.3	13.0	11.3	15.0	13.0
4. Булган	9	3	7	18.9	8.3	14.3	10	7	10	21.1	18.5	21.1	19.4	18.5
5. Говь-Алтай	8	10	12	10.8	15.7	14.7	9	13	15	12.2	17.8	12.2	20.4	17.8
6. Говьсүмбэр	3	1	2	11.1	4.1	6.1	3	2	3	11.1	8.8	11.1	8.2	8.8
7. Дархан-Уул	15	10	15	9.8	7.2	9.5	18	12	18	11.8	11.6	11.8	8.7	11.6
8. Дорноговь	10	9	10	12.2	11.6	10.5	12	13	13	14.7	13.7	14.7	16.7	13.7
9. Дорнод	6	6	12	5.2	5.9	9.8	10	11	17	8.7	13.7	8.7	10.8	13.7
10. Дундговь	4	1	4	7.7	2.3	6.8	7	2	5	13.4	9.0	13.4	4.7	9.0
11. Завхан	10	13	15	11.4	17.8	16.4	14	18	19	16.0	21.5	16.0	24.6	21.5
12. Орхон	16	13	15	9.4	8.8	8.7	19	13	17	11.1	9.8	11.1	8.8	9.8
13. Өвөрхангай	21	16	19	14.0	12.3	12.1	26	20	22	17.4	14.4	17.4	15.3	14.4
14. Өмнөговь	10	12	13	9.4	13.4	12.3	11	12	15	10.3	13.6	10.3	13.4	13.6
